



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2023/24/-НА-СТА-ТТ3

ТӨВ АЙМГИЙН АЛТАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2022 ОНЫ
САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2023 он

Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Ж.Бямбацогт

Утас: 70272248 Цахим хаяг: byambatsogtj@audit.gov.mn



Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн жагсаалт	3
Хүснэгтийн жагсаалт	3
1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	4
Асуудлыг онцолсон хэсэг	Error! Bookmark not defined.
Аудитын гол асуудал	Error! Bookmark not defined.
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	6
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	12
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	12
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	13
3.4.1 Мөнгөн хөрөнгө.....	14
3.4.2 Авлага.....	14
3.4.3 Бараа материал	15
3.4.4 Үндсэн хөрөнгө	15
3.4.5 Өр төлбөр	16
3.4.6 Засгийн газрын хувь оролцоо	16
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	17
3.5.1 Төсвийн төлөвлөлт	17
3.5.2 Төсвийн гүйцэтгэл.....	17
3.5.3 Нэмэлт төсөв.....	18
3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн.....	18
4. АУДИТЫН ТАЙЛАН	20
4.1 Ерөнхий зүйл.....	20
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	21
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	21
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	21
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	22
4.5.1 Завсрын аудитын талаар	22
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	22
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	23
5.1 Залруулсан алдаа	23
5.2 Албан шаардлага	24
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	25

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн газар

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1 Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт.....	13
Хүснэгт 2 Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл.....	14
Хүснэгт 3 Авлагын үлдэгдэл	14
Хүснэгт 4 Бараа материалын үлдэгдэл.....	15
Хүснэгт 5 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл	15
Хүснэгт 6 Нийт өр төлбөрийн үлдэгдэл	16
Хүснэгт 7 Засгийн газрын хувь оролцоо	16
Хүснэгт 8 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл	17
Хүснэгт 9 Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт	18
Хүснэгт 10 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт.....	22

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТОРЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шүүдэн: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2023.03.24 № 01/247.
танай -ны № -т

ТӨВ АЙМГИЙН АЛТАНБУЛАГ СУМЫН
ЗАСАГ ДАРГА Д.БАТСУУРЬ ТАНАА

Г Г

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Төв аймгийн Алтанбулаг сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Алтанбулаг сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төв аймгийн Алтанбулаг сумын Засаг даргын 2022 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн зорилт, арга хэмжээний хэрэгжилт, үйл ажиллагааны үр дүнг 91,5 хувьтай, “Ногоон хөгжил-баялаг бүтээгчид”-ийг дэмжих урианы жилийн хөтөлбөр, арга хэмжээг 92,3 хувьтай тус тус хэрэгжүүлсэн байна.

Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан, тодруулга тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материалыг 5,000.0 мянган төгрөгөөр, үндсэн хөрөнгийг 7,193.6 мянган төгрөгөөр зөрүүтэй нэгтгэсэн байна.

Аудитын гол асуудал

Тухайн байгууллагын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл бүхий ажил гүйлгээ байхгүй байна.

Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө 112,5 хувиар давж биелсэн боловч 6 нэр төрлийн орлого 14,1-54,5 хувиар буюу 141,684.8 мянган төгрөгөөр тасарсан байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний

олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайландаа төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бodoх бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бodoх бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.


Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ анgid эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2021 оны 12 сарын 31	2022 оны 12 сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		1,104,292.96	1,402,716.56
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	За 3б	498,597.78	559,759.77
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	315,848.94	714,500.52
34	УРЬДЧИЛГАА	8а, 8б, 8в	-	-
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	289,846.24	128,456.28
36	НӨӨЦИЙН БАРАА	9а	-	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		14,996,295.40	10,030,542.01
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	12а, 12б, 12в	-	-
39200	Биет хөрөнгө		14,715,453.29	9,974,434.01
39300	Биет бус хөрөнгө		280,842.11	56,108.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		16,100,588.36	11,433,258.58
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		2,781.88	958.47
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	2,781.88	958.47
41300	Өглөг	17а, 17б	2,781.88	958.47
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		16,097,806.48	11,432,300.11
51	Засгийн газрын хувь оролцоо		16,097,806.48	11,432,300.11
51100	Засгийн газрын оруулсан капитал		1,731,046.97	735,484.95
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө		1,731,046.97	735,484.95
51200	Хуримтлагдсан үр дүн		12,025,073.88	10,315,255.01
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		2,341,685.63	381,560.15
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		16,100,588.36	11,433,258.58

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	2021 оны 12 сарын 31	2022 оны 12 сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	5,331,708.16	2,248,835.56
11	ТАТВАРЫН ОРЛОГО	457,568.40	1,074,769.70
110	Орлогын албан татвар	65,609.44	673,855.84
1100	Хувь хүний орлогын албан татвар	65,609.44	693,661.35
113	Хөрөнгийн албан татвар	63,925.90	131,055.96
118	Бусад татвар, төлбөр, хураамж	328,033.07	269,857.91
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	164,812.36	178,163.04
1181	Газрын төлбөр	6,471.54	33,378.75
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	156,749.17	58,316.12
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,304,579.92	453,922.82
120	Нийтлэг татварын бус орлого	1,304,579.92	453,922.82
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,569,559.84	720,143.03
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,508,076.60	253,990.20
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	372,671.37	301,009.13
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,668,116.10	165,143.70
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	20,695.76	-
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,199,482.59	2,309,104.22
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,044,397.17	2,244,878.72
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,496,771.58	360,235.06
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	198,467.05	48,459.99
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	386,349.57	400,448.02
2104	Хангамж, бараа материалын зардал	95,953.10	40,704.48
2105	Нормативт зардал	263,744.28	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19,180.15	21,526.50
2107	Томилолт, зочны зардал	3,361.00	4,654.90
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	34,317.05	17,016.16
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,546,253.39	1,351,833.62
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,155,085.42	64,225.50
2132	Бусад урсгал шилжүүлэг	74,895.24	64,225.50
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,034,103.67	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	46,086.51	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	56,214.90	213,373.13
2200	Дотоод эх үүсвэрээр	56,214.90	213,373.13
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	5,255,697.49	2,522,477.35
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	2,590.27	-
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	301,681.58	4,339,299.48

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/ мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	2021 оны 12 сарын 31	2022 оны 12 сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	4,269,415.70	2,003,529.22
11	ТАТВАРЫН ОРЛОГО	457,568.40	1,074,769.70
110	Орлогын албан татвар	65,609.44	673,855.84
1100	Хувь хүний орлогын албан татвар	65,609.44	693,661.35
113	Хөрөнгийн албан татвар	63,925.90	131,055.96
118	Бусад татвар, төлбөр, хураамж	328,033.07	269,857.91
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	164,812.36	178,163.04
1181	Газрын төлбөр	6,471.54	33,378.75
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	156,749.17	58,316.12
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	293,979.28	208,616.48
120	Нийтлэг татварын бус орлого	293,979.28	208,616.48
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,517,868.02	720,143.03
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,508,076.60	253,990.20
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	320,979.55	301,009.13
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,668,116.10	165,143.70
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	20,695.76	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,719,064.21	1,223,432.31
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,719,064.21	1,223,432.31
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,566,153.60	1,132,140.47
2101	Цалин хэлс болон нэмэгдэл урамшил	1,496,700.66	336,876.57
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	198,506.88	42,590.91
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	386,122.57	400,514.02
2104	Хангамж, бараа материалын зардал	131,535.33	70,469.65
2105	Нормативт зардал	110,317.59	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	23,226.78	19,672.70
2107	Томилолт, зочны зардал	3,361.00	3,281.30
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	49,152.15	42,827.06
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	167,230.65	215,908.27
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,152,910.61	91,291.84
2132	Бусад урсгал шилжүүлэг	72,720.43	88,183.70
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,034,103.67	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	46,086.51	3,108.14
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	112,254.54	555,311.11
2200	Дотоод эх үүсвэрээр	112,254.54	555,311.11
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	550,351.49	780,096.91
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	112,254.54	555,311.11
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(112,254.54)	(555,311.11)

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,731,046.97	16,320,887.12
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,731,046.97	16,322,268.30
9	Тайлант үеийн үр дүн	-	(223,080.64)
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,731,046.97	16,097,806.48
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,731,046.97	16,097,806.48
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(995,562.02)	(3,977,004.55)
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	735,484.95	12,120,801.93
19	Тайлант үеийн үр дүн	-	(4,612,941.27)
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	735,484.95	11,432,300.11

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,804,927.20	1,606,044.97	199,525.37
21	УРСГАЛ ЗАРДАЛ	969,427.20	933,981.94	35,901.55
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	956,144.70	920,699.45	15,246.15
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	350,915.60	336,876.57	-
210101	Үндсэн цалин	252,342.90	259,862.00	-
210102	Нэмэгдэл	72,238.40	51,528.66	-
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	342.00	-
210104	Урамшуулал	26,334.30	25,143.91	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	45,009.80	42,590.91	-
210201	Тэтгэврийн даатгал	30,729.50	29,155.87	-
210202	Тэтгэмжийн даатгал	3,752.60	3,361.27	-
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,807.60	2,689.21	-
210204	Ажилгүйдлийн даатгал	701.80	672.20	-
210205	Эрүүл мэндийн даатгал	7,018.30	6,712.37	-
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	409,978.90	400,514.02	-
210301	Гэрэл, цахилгаан	37,888.10	38,169.29	-
210302	Тулш, халаалт	369,308.80	358,872.72	-
210303	Цэвэр, бохир ус	2,782.00	3,472.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	28,433.00	26,185.10	-
210401	Бичиг хэрэг	1,725.10	2,041.56	-
210402	Тээвэр, шатахуун	14,732.20	14,270.34	-
210403	Шудан, холбоо, интернэтийн төлбөр	1,975.70	2,116.90	-
210405	Хог хаягдал зайлцуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	10,000.00	7,756.30	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19,826.20	18,525.70	(2,500.00)
210604	Урсгал засвар	19,826.20	18,525.70	(2,500.00)
2107	Томилотт, зочны зардал	3,330.80	3,281.30	-
210702	Дотоод албан томилотт	3,330.80	3,281.30	-
2108	Бусдаа гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	43,141.40	41,322.40	-
210801	Бусдаа гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	41,521.40	39,703.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	540.00	540.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	400.00	399.43	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	400.00	399.98	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	280.00	280.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	55,509.00	51,403.45	17,746.15
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	52,509.00	48,403.45	17,746.15
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,000.00	3,000.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,282.50	13,282.50	20,655.40
2132	Бусад урсгал шилжүүлэг	13,282.50	13,282.50	20,655.40
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	11,282.50	11,282.50	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000.00	2,000.00	20,655.40
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	635,500.00	508,439.21	-
220001	Барилга байгууламж	250,000.00	250,000.00	-
221001	Их засвар	55,719.00	55,719.00	-
222001	Тоног төхөөрөмж	76,000.00	-	-
223001	Бусад хөрөнгө	253,781.00	202,720.21	-
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	200,000.00	163,623.82	163,623.82
230001	Эргэж төлөгдхээ зээл	200,000.00	163,623.82	-
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,804,927.20	1,503,219.02	157,424.50
31	УЛСЫН ТӨССӨВӨС САНХҮҮЖИХ	253,990.20	253,990.20	(873,633.64)
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	253,990.20	253,990.20	253,990.20
32	ОРОН НУТГИЙН ТӨССӨВӨС САНХҮҮЖИХ	1,138,607.20	1,127,623.84	909,467.35
320001	Орон нутгийн төсвөөс	1,138,607.20	1,127,623.84	1,163,457.55
35	ТӨССӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАНААС	412,329.80	121,604.98	121,590.80
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	200,000.00	121,604.98	-
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	212,329.80	-	3,496.59
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл□	-	222,954.93	222,954.93
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл□	-	118,987.77	134,736.23

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Тайллангиин үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	319,012.62	332,098.43
21	УРСГАЛ ЗАРДАЛ	319,012.62	332,098.43
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	264,541.65	194,244.07
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	26,430.13	-
210101	Үндсэн цалин	26,430.13	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8,430.45	-
210201	Тэтгэврийн даатгал	8,430.45	-
2104	Хангамж, бараа материалын зардал	7,758.56	3,281.40
210401	Бичиг хэрэг	1,125.11	-
210402	Тээвэр, шатахуун	6,633.45	3,281.40
2105	Нормативт зардал	53,088.13	-
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	46,991.31	-
210502	Хоол, хүнс	6,096.82	-
2106	Эд хогшил, ургал засварын зардал	7,701.40	1,147.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,045.00	-
210604	Ургал засвар	656.40	1,147.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	56,290.05	1,494.36
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	56,290.05	1,494.36
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	104,842.93	188,321.32
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	104,742.93	188,321.32
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	100.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	54,470.96	137,854.36
2132	Бусад ургал шилжүүлэг	24,497.10	95,556.60
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	7,343.20
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	13,832.30	-
213208	Хөдөө орон нутгийн төгтвэр суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	9,156.80	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,508.00	88,213.40
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	29,973.86	42,297.76
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	29,122.36	40,330.82
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	-	1,966.94
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	851.50	-
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	320,979.55	330,131.49
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	320,979.55	330,131.49
131101	Төрийн болон орон нутгийн өмчийт бус этгээдээс авсан хандив, тусламж	94,582.30	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	160,265.97	271,324.94
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	66,131.28	58,806.56
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	1,966.94
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,966.94	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Алтанбулаг сумын Засаг дарга нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1-д “Засаг дарга нь харьялах нутаг дэвсгэртээ хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, харьялах дээд шатны Засаг даргын шийдвэрийн гүйцэтгэлийг хангах, түүнчлэн тухайн Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн төлөөлөгч мөн” гэж заасан ба мөн хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1-д “Сумын Засаг дарга харьялах нутаг дэвсгэрийн хэмжээнд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу 59.1.1-59.1.23-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлдэг байна.

Мөн Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-д “Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу 14.2.1-14.2.12-т заасан бүрэн эрхийг, мөн хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-д “Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьялагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасан бүрэн эрхийг тус тус хэрэгжүүлэн, Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаа аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчид нэгтгэн тайлагнадаг байна.

Иргэдийн аятай тухтай амьдрах нөхцөл боломжийг бүрдүүлэн Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хувийн компани 100%-ийн хөрөнгө оруулалтаар сумын төвийг төвлөрсөн халаалтын системд холбох, төрийн албан хаагч, залуу гэр бүлийг хямд үнэтэй орон сууцаар хангах бодлогын хүрээнд 12 айлын “Хаус” хорооллын барилгын ажлыг эхлүүлэх, Улаанбаатар хоттой сумын төвийг засмал замаар холбосон, шинэ сууршилийн бус болон захын хороололд 472 сая төгрөгийн эрчим хүчиний сайжруулалт хийх, иргэнд газар өмчлүүлэхэд сумын үндсэн иргэдийн эрх ашгийг нэн тэргүүнд тавьж 4927 иргэнд 2,087.9 га газар өмчлүүлэх, “Эко тохилог хашаа” төслийг хэрэгжүүлэх, мах, сүүний үйлдвэрүүдийг байгуулан ажиллуулж МАА-н гаралтай бүтээгдэхүүнийг сумандаа боловсруулж үйлдвэрлэж байна.

Төв аймгийн Алтанбулаг сумын Засаг даргын 2022 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн зорилт, арга хэмжээний хэрэгжилт, үйл ажиллагааны үр дүнг 91,5 хувьтай, “Ногоон хөгжил-баялаг бүтээгчид”-ийг дэмжих урианы жилийн хөтөлбөр, арга хэмжээг 92,3 хувьтай тус тус хэрэгжүүлсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Алтанбулаг сумын Засаг дарга нь үйл ажиллагаандaa Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль Шилэн дансны тухай хууль зэргийг үйл ажиллагаандaa мөрдлөг болгон ажиллаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамрагдаагүй, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Сумын Засаг даргын баталсан удирдамж төлөвлөгөөний дагуу ЕБС, сургуулийн өмнөх боловсролын үйл ажиллагаа, Худалдаа үйлчилгээний байгууллагуудын албан татвар, төлбөр хураамж төлж байгаа эсэхэд, төсөөвт байгууллагуудын нягтлан бодох бүртгэл хөтлөлт, анхан шатны баримтын бүрдүүлэлт зэрэгт хяналт хийж, ажлын дүгнэлт тайланг бичсэн байна.

Төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайланын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайланын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшилийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Алтанбулаг сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төв аймгийн Алтанбулаг сумын Засаг даргын нэгтгэсэн тайландаа мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Алтанбулаг сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 11,433,259.58 мянган төгрөг болж, өмнөх оноос 4,667,330.78 мянган төгрөгөөр буюу 28,9 хувиар буурсан байна.

Хүснэгт 1 Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	498,597.78	559,759.77	61,161.99
Авлага	315,848.94	714,500.52	398,651.58
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	289,846.24	128,456.28	(161,389.96)
Нөөцийн бараа	-	-	-
Үндсэн хөрөнгө	14,996,295.40	10,030,542.01	(4,965,753.39)
Нийт хөрөнгийн дүн	16,100,588.36	11,433,258.58	(4,667,329.78)
Нийт өр төлбөр	2,781.88	958.47	(1,823.41)
Цэвэр хөрөнгө өмчийн дүн	16,097,806.48	11,432,300.11	(4,665,506.37)
Өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн	16,100,588.36	11,433,258.58	(4,667,329.78)

Эх сурвалж: Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Дээрх хүснэгтээс мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 559,759.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 61,161.9 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь орон нутгийн ерөнхий орлогын данс 382,841.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 134,490.1 мянган төгрөгөөр, Төв Алтанбулаг тохижилт үйлчилгээ ОНΘААТҮГ-ын үлдэгдэл 23,589.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 23,589.7 мянган төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна.

Авлагын эцсийн үлдэгдэл 714,500.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 398,651.6 мянган төгрөгөөр өссөн нь ОНХС-ийн авлага 266,637.5 мянган төгрөгөөр, ЗДТГ-ын авлага 159,000.0 мянган төгрөгөөр өмнөх оноос өссөн нь шалтгаалсан байна.

Бараа материалын эцсийн үлдэгдэл 128,456.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 161,389.9 мянган төгрөгөөр буурсан нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих улсын төсвийн байгууллагууд харьяа байгууллагууддаа санхүүгийн тайлангаа нэгтгэдэг болсноор Эрүүл мэндийн төвийн 44,318.2 мянган төгрөг, ЕБС-ийн 87,083.6 мянган төгрөг, СӨБ-ийн 34,659.2 мянган төгрөг, Соёлын төвийн 24,716.2 мянган төгрөгийн, нийт 190,777.2 мянган төгрөгийн бараа материалыг шилжүүлсэн нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 10,030,542.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 4,965,329.8 мянган төгрөгөөр буурсан нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих улсын төсвийн ЕБС, Цэцэрлэг, Эмнэлэг, Соёлын төвийн байгууллагуудын 4,146,385.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг шилжүүлснээс шалтгаалсан байна.

Засгийн газрын хувь оролцоо /Эздиийн өмч/ 11,432,300.1 мянган төгрөг болж, өмнөх оноос 4,665,506.4 мянган төгрөгөөр буурсан нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих улсын төсвийн ЕБС, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төвийн, Соёлын төвийн байгууллагуудын авлага, засгийн газрын сан, дахин үнэлгээний нэмэгдлийг өмнөх үеийн үр дүн дансанд хааж, тайлант оны үр дүн 4,389,617.5 мянган төгрөгөөр буурснаас шалтгаалсан байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 559,759.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 61,161.9 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2 Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (-)
Төрийн сангийн харилцах	487,807.07	518,460.01	30,652.94
Арилжааны банк дахь харилцах	8,823.78	41,299.75	32,475.97
Нэмэлт санхүүжилтийн харилцах	1,966.94	-	(1,966.94)
Банкинд байгаа бэлэн мөнгөн дүн	498,597.78	559,759.77	61,161.99

Эх сурвалж: Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгээсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн төрийн сангийн харилцах дансны эцсийн үлдэгдэл 518,460.0 мянган төгрөгийн 68,4 хувь буюу 382,841.9 мянган төгрөгийг орон нутгийн төсвийн орлогын, 6,4 хувь буюу 35,616.0 мянган төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангийн, 14,9 хувь буюу 83,371.8 мянган төгрөгийг хоршоо хөгжүүлэх сангийн, 3 хувь буюу 16,630.3 мянган төгрөгийг байгалийн нөхөн сэргээлт барьцаа сангийн дансны үлдэгдэл эзэлж байна. Арилжааны банкны үлдэгдэл 41,299.8 мянган төгрөгийн 57,1 хувь болох 23,589.7 мянган төгрөгийг “Төв Алтанбулаг тохижилт үйлчилгээ” ОНӨГ-ын үлдэгдэл, 17,710.1 мянган төгрөг буюу 42,9 хувийг эмийн эргэлтийн сангийн үлдэгдэл эзэлж байна.

Аудитын илрүүлэлт

Шалгагдагч байгууллагын харилцаагч байгууллагатай хийсэн худалдан авалтыг цахим төлбөрийн баримттай тулгалт хийхэд ЗДТГ 180,805.7 мянган төгрөгийн худалдан авалтыг баталгаажуулаагүй байна.

3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 714,500.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 398,651.6 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3 Авлагын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (-)
Зээлийн хүүгийн авлага	3,557.18	5,219.88	1,662.70
Дансны авлага /ТӨҮГ/	3,166.41	257.05	(2,909.36)
Байгууллагаас авах авлага	74,744.72	425,637.50	350,892.78
Хувь хүмүүсээс авах авлага	234,380.62	283,386.10	49,005.48
Банкинд байгаа бэлэн мөнгөн дүн	315,848.94	714,500.52	398,651.58

Эх сурвалж: Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгээсэн тайлан

Авлага дансны эцсийн үлдэгдэл 714,500.5 мянган төгрөгийн 0,7 хувь буюу 5,219.9 мянган төгрөгийг зээлийн хүүгийн авлага, 59,6 хувь буюу 425,637.5 мянган төгрөгийг байгууллагаас авах, 39,7 хувь буюу 283,386.1 мянган төгрөгийг хувь хүмүүсээс авах авлага дансны үлдэгдэл эзэлж байна. Хувь хүмүүсээс авах авлагын 100 хувь буюу 283,386.1 мянган төгрөг нь хоршоо, хөгжүүлэх сангийн авлага байна.

Аудитын илрүүлэлт

Төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн тайланд аудит хийх явцад хоршоо хөгжүүлэх сангийн 288,386.1 мянган төгрөгийн авлагыг зээлийн авлага, хувь хүмүүсээс авах авлага гэж 2 өөр дансанд бүртгэсэн байна.

3.4.3 Бараа материал

Бараа материал дансны эцсийн үлдэгдэл 128,456.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 161,390.0 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 4 Бараа материалын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (-)
Тусгай зориулалттай материал	32,696.34	31,699.63	(996.71)
Эм боох материал	22,967.28	-	(22,967.28)
Дуусаагүй үйлдвэрлэл	-	18,662.51	18,662.51
Бичиг хэргийн материал	1,367.70	-	(1,367.70)
Аж ахуйн материал	197,447.82	73,094.14	(124,353.68)
Сэлбэг хэрэгсэл	1,800.20	-	(1,800.20)
Хүнсний материал	3,081.96	-	(3,081.96)
Бусад хангамжийн материал	25,534.95	-	(25,534.95)
Мал амьтад	4,950.00	5,000.00	50.00
БАРАА МАТЕРИАЛ	289,846.24	128,456.28	(161,389.96)

Эх сурвалж: Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын эцсийн үлдэгдэл 128,456.3 мянган төгрөгийн 58,1 хувийг ЗДТГ, 24.7 хувийг эмийн эргэлтийн сан, 2.7 хувийг ИТХ, 14.5 хувийг ОНХС-ын бараа материал эзэлж байна.

Бараа материалын эцсийн үлдэгдэл 128,456.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 161,389.9 мянган төгрөгөөр буурсан нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих улсын төсвийн байгууллагууд харьяа байгууллагууддаа санхүүгийн тайлангаа нэгтгэдэг болсноор Эрүүл мэндийн төвийн 44,318.2 мянган төгрөг, ЕБС-ийн 87,083.6 мянган төгрөг, СӨБ-ийн 34,659.2 мянган төгрөг, Соёлын төвийн 24,716.2 мянган төгрөгийн, нийт 190,777.2 мянган төгрөгийн бараа материалыг улсын төсвийн байгууллагад шилжүүлсэнтэй холбоотой байна.

3.4.4 Үндсэн хөрөнгө

Хүснэгт 5 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (-)
Барилга, байгууламж, орон сууц	5,431,410.10	1,694,929.59	(3,736,480.51)
Авто-тээврийн хэрэгсэл	411,935.28	446,252.33	34,317.05
Машин тоног төхөөрөмж(компьютер)	522,262.60	208,263.14	(313,999.46)
Тавилга, аж ахуйн эд хогшил	260,824.24	63,750.52	(197,073.72)
Зам, гүүрийн байгууламж	10,674,041.63	10,674,041.63	-
Бусад үндсэн хөрөнгө	267,410.20	326,648.18	59,237.98
Ном	48,026.28	21,818.20	(26,208.08)
Програм хангамж	1,535.00	-	(1,535.00)
Бусад биет бус хөрөнгө	290,236.00	65,778.00	(224,458.00)
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	14,996,295.40	10,030,542.01	(4,965,753.39)

Үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 10,030,542.0 мянган төгрөгийн 99,9 хувийг буюу 10,026,909.1 мянган төгрөгийг ЗДТГ, 265.3 мянган төгрөгийг эмийн эргэлтийн сан, 2,617.6 мянган төгрөгийг ИХХ, 750.0 мянган төгрөгийг хоршоо хөгжүүлэх сангийн хөрөнгө эзэлж байна.

Үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 10,030,542.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 4,965,329.8 мянган төгрөгөөр буурсан нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих улсын төсвийн ЕБС, Цэцэрлэг, Эмнэлэг, Соёлын төвийн байгууллагуудын 4,146,385.2 мянган төгрөгийн, нийт 6,473,867.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг шилжүүлсэнтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

ЗДТГ-ын санхүүгийн тайлангийн аудитаар элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 589,324.0 мянган төгрөгийн өртгөтэй 1025 ширхэг үндсэн хөрөнгө бүртгэлтэй байгаа зөрчилд зөвлөмж өгсөн.

3.4.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 958.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 1,823.4 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 6 Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/ мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (-)
Ажилчидтай холбогдсон өглөг	-	228.47	228.47
Бараа үйлчилгээний зардлын өглөг	2,781.88	730.00	(2,051.88)
НИЙТ ӨР ТӨЛБӨР	2,781.88	958.47	(1,823.41)

Эх сурвалж: Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөр дансны эцсийн үлдэгдэл 1,823.4 мянган төгрөгөөр буурсан нь ЭМТ, ЕБС, СӨБ, соёлын төв нь улсын төсөвт байгууллага болж орон нутгийн төвлөрүүлэн захирагчийн тайланд нэгтгэгдэхгүй болсонтой холбоотой байна.

Өр төлбөрийн жилийн эцсийн 958.5 мянган төгрөгийн үлдэгдлийн 600.0 мянган төгрөг нь орон нутгийн хөгжлийн сангийн, 228.5 мянган төгрөг нь эмийн эргэлтийн сангийн, 130.0 мянган төгрөг нь байгалийн нөхөн сэргээлтийн барьцаа сангийн өглөг эзэлж байна.

Аудитын илрүүлэлт:

Байгалийн нөхөн сэргээлтийн барьцаа санд байршуулсан 130.0 мянган төгрөгийг өглөгөөр бүртгэлгүй орлого гэж хүлээн зөвшөөрч бүртгэсэн байсныг аудитын явцад запруулсан.

3.4.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 11,432,300.1 мянган төгрөг болж, өмнөх оноос 4,665,506.4 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 7 Засгийн газрын хувь оролцоо

/ мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал	1,731,046.97	735,484.95	(995,562.02)
Хуримтлагдсан үр дүн	12,025,073.88	10,315,255.01	(1,709,818.87)
Өмнөх үеийн үр дүн	12,248,154.52	14,928,196.29	2,680,041.77
Тайлант үеийн үр дүн	(223,080.64)	(4,612,941.27)	(4,389,860.63)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,341,685.63	381,560.15	(1,960,125.48)
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	16,097,806.48	11,432,300.11	(4,665,506.37)

Эх сурвалж: Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл өмнөх оноос 4,665,506.4 мянган төгрөгөөр буурсан нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих улсын төсвийн байгууллагуудын хөрөнгийг шилжүүлснээр засгийн газрын сан 995,562.0 мянган төгрөгөөр, хөрөнгийн дахин үнэлгээ 1,960,125.5 мянган төгрөгөөр буурч, өмнөх үеийн үр дүн 2,680,041.5 мянган төгрөгөөр нэмэгдэж, тайлант үеийн үр дүн 4,389,860.6 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Алтанбулаг сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн “сумын 2022 оны төсөв батлах тухай” 06 дугаар тогтоолоор 2022 онд төсөвт төвлөрүүлэх татварын ба татварын бус орлогыг 974,467.2 мянган төгрөгөөр, төсвийн жилд зарцуулах зарлагын нийт хэмжээг 1,703,876.4 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Алтанбулаг сумын ИТХ-ын 2022 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн “Сумын 2022 оны тодотгосон төсөв батлах тухай” 02 дугаар тогтоолоор орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 1,003.7 мянган төгрөгөөр бууруулан 973,463.5 мянган төгрөгөөр, 2022 оны төсвийн жилд зарцуулах зарлагын хэмжээг 1,604,927.2 мянган төгрөгөөр, хоршоо хөгжүүлэх сангийн эх үүсвэрийг 201,500.0 мянган төгрөгөөр, нийт 1,806,427.2 мянган төгрөгийг тодотгон баталсан байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 9 хөтөлбөрийн 13 арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвийн орлогоос 973,463.5 мянган төгрөг, орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэгээс 165,143.7 мянган төгрөг, орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг 253,990.9 мянган төгрөг, шилжих үлдэгдлээс 80,009.9 мянган төгрөг, урьд оны малын тоо толгойн албан татварын үдэгдлээс 47,719.0 мянган төгрөг, төсвийн урьд оны шилжих үлдэгдлээс 84,600.2 мянган төгрөг, хоршоо хөгжүүлэх сангийн эх үүсвэрээс 201,500.0 мянган төгрөгийг бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр аймгийн төсвөөс санхүүгийн дэмжлэг 165,143.7 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 1,163,457.5 мянган төгрөгийн санхүүжилтийг олгож, 35,833.7 мянган төгрөгийн үлдэгдлийг төсөвт буцаан төвлөрүүлж төсвийн тохируулга хийгдсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,606,044.9 мянган төгрөг буюу 88,9 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулалтын зардал 14,039.1 мянган төгрөг, байр ашиглахтай холбоотой зардал 464.9 мянган төгрөг, хангамж бараа материалын зардал 2,247.9 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардал 1,300.5 мянган төгрөг, дотоод томилолтын зардал 49.5 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ 1,819.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 4,105.5 мянган төгрөг, хөрөнгийн зардал 127,060.8 мянган төгрөгөөр хэмнэснээс шалтгаалсан байна.

Цалин шимтгэлийн зардал орон тоо дутуу ажилласнаас, хөрөнгийн зардал тендер сонгон шалгаруулалттай холбоотойгоор хэмнэгдсэн байна.

Хүснэгт 8 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Хөтөлбөр арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлтийн хувь
1	Орон нутгийн өөрөө ёсны удирдах	81,641.0	65,892.5	15,748.5	80.7

	байгууллагын үндсэн үйл ажиллагааны зардал				
2	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага үндсэн үйл ажиллагааны зардал	498,003.3	488,048.7	9,954.6	98
3	Ерөнхий боловсролын сургуулийн тогтмол зардал	212,313.7	211,684.0	629.7	99.7
4	Эрүүл мэндийн төвийн тогтмол зардал	30,460.5	27,911.5	2,549.0	91.0
5	Цэцэрлэгийн тогмол зардал	62,130.7	60,949.0	1,181.7	98.0
6	Соёлын төвийн тогтмол зардал	116,198.0	110,996.0	5,202.0	95.5
7	Хоршоо хөгжүүлэх сангийн үйл ажиллагааны зардал	201,500.0	163,623.8	37,876.2	81.2
8	Орон нутгийн хөгжлийн сангийн төсөл арга хэмжээний зардал	604,000.0	476,939.2	127,060.8	78.9
	Дүн	1,806,427.2	1,606,044.9		

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв. түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн харилцах дансаар сумын Засаг даргын тамгын газар нь 289,400.6 мянган төгрөг, ИТХ 400.0 мянган нийт 289,800.6 мянган төгрөгийг зарцуулсан байна

Нэмэлт төсвийн тайланг орлого. зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хөтөлбөр хэрэгжих хугацаанд нийт 8 хөтөлбөрийн 21 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 9 Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
---	----------	------------------	--------------	------------------	-----------------	------------

1	70105-Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага	2022.01.01 2022.12.31	Сумын ИТХТ, тэргүүлэгчдийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай ажил үйлчилгээгээр хангах, мэргэшсэн тогтвортой өндөр чадавх бүхий аппарат бүрдүүлж, хуралдааныг зохион байгуулж, мэдээллээр тасралтгүй хангахад оршино. Жилд 4-өөс доошгүй удаа хурал хийнэ.	Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч, тэргүүлэгчдийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай ажил үйлчилгээгээр хангах, мэргэшсэн тогтвортой өндөр чадавх бүхий аппарат бүрдүүлж, Иргэдийн төлөөлөгчдийн хурал, тэргүүлэгчдийн хуралдааныг зохион байгуулж жилд 12 удаа хуралдсан байна. Хэрэгжилт 99.4 %	81,641.0	65,892.5
2	70106-Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	2022.01.01 2022.12.31	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага 6 зорилт, хэрэгжүүлэх 78 арга хэмжээ хэрэгжүүлэх	Хөтөлбөрийн хэрэгжилт 99,6%	498,003.3	488,048.7
3	70106-Хоршоо хөгжүүлэх сан	2022.01.01 2022.12.31	2022 оны 1 сараас Сум хөгжүүлэх санг шинээр Хоршоо хөгжүүлэх сан болгон журмыг дагаж мөрдөх ХХС-аас иргэн, хоршоонд олгох зээлийг журмын дагуу шаардлага хангасан төсөл шалгаруулсан зээл олгох	2022 оны 01 сараас Хоршоо хөгжүүлэх сан болж журмын дагуу шинэчлэгдсэн. Хэрэгжилт 100% Хоршоо хөгжүүлэх сангаас зээл олгох төсөл хөтөлбөр зээлийн сонгон шалгаруулалт зарлагдаж тэнцсэн төсөлд зээл олгосон байна.	201,500.0	163,623.8
4	71802-Ерөнхий боловсролын сургууль	2022.01.01 2022.12.31	Ерөнхий боловсрол сургууль нь 9 зорилт 31 арга хэмжээ хэрэгжүүлэх	2022 онд “Багшийн гүйцэтгэлийн үнэлгээ” сургуулийн дундаж 67%, Хөтөлбөрийн хэрэгжилт 91.4%, “	212,313.7	211,684.0
5	71801-Сургуулийн өмнөх боловсрол	2022.01.01 2022.12.31	Сургуулийн өмнөх боловсрол нь 14 зорилт 51 арга хэмжээ хэрэгжүүлэх	Хөтөлбөрийн хэрэгжилт 71.5 %	62,130.7	60,949.0
6	71702-Соёлын үйлчилгээ	2022.01.01 2022.12.31	Соёлын төв нь 6 зорилт 32 арга хэмжээ хэрэгжүүлэх	Хөтөлбөрийн хэрэгжилт 97%	116,198.0	110,996.0

7	71602-Эрүүл мэндийн төв	2022.01.01 2022.12.31	Нийт 8 төрлийн үзлэгт 2385 хүн, Эрүүл мэндийн даатгалын 4 багцын тусlamж үйлчилгээнд 364 иргэдийг хамруулна.	Нийт 8 төрлийн эрт илрүүлэг үзлэгт 2897 хүн, чихрийн шижин өвчний эрт илрүүлэг үзлэгт 660/100%, артерийн даралтны эрт илрүүлэг 1119/100%, хөхний хавдар илрүүлэх үзлэгт 362/91.1%, умайн хүзүүний эрт илрүүлэг 44/57.8% БЗДХ илрүүлэх 463/92.3%, элэгний В С илрүүлэгт 249/88.6% иргэн хамрагдаж нийт 88.3%. байна ЭМД-ын 4 багцын тусlamж үйлчилгээний Өдрийн эмчилгээний багц- 46 иргэн Сэргээн засах эмчилгээний багц 73 иргэн гэрийн эргэлтийн багцад- 102 иргэн, Оношилгоо шинжилгээний багц 312 иргэн нийт 533 иргэн тус тус хамрагдсан	30,460.5	27,911.5
8	70106-Орон нутгийн хөгжлийн сан	2022.01.01 2022.12.31	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр шинээр хэрэгжих 14 төслийг 604000,0 мянган төгрөгөөр хийж гүйцэтгэнэ.	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 9, мөнгийг нь дутуу шилжүүлсэн 3 ажил байна. Хэрэгжээгүй 2 ажил байна. Хэрэгжилт 78,9%	604,000.0	476,939.2
Нийт дүн					1,806,427.2	1,606,044.9

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дунд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Алтанбулаг сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланда аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын орлого бүрдүүлэлт, шилэн дансны мэдээллийг сайжруулахтай холбоотой ёгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Бямбацогт гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Алтанбулаг сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт сумын Засаг даргын 2023 оны 3 дугаар сарын 05-ны өдрийн 05/62 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сумын Иргэдийн Төлөвлөгчдийн Хурлаас баталсан 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн, суурь үзүүлэлтийг нийт зардал 5,255,697.5 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 78.835.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 63,068.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянах шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төв аймгийн Алтанбулаг сумын Засаг дарга нь Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар мэдээлэл ирүүлээгүй болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Алтанбулаг сумын Засаг даргын шилэн дансны цахим хуудсанд өөрчлөгдсөн ерөнхий нягтлан бодогчийн нэрийг солиогүй, тайлант онд байршуулбал зохих мэдээллээс 10 мэдээллийг хугацаа хоцроож, 1 мэдээллийг байршуулаагүй төлөвтэй байна. Хоршоо хөгжүүлэх сангийн орлогын 1 гүйлгээ, зарлагын 9 гүйлгээг мэдээлээгүй ба зээл олголттой холбоотой 171,809.8 мянган төгрөгийн хөрөнгө зарцуулахтай холбоотой 1 тушаал болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн 35,000.0 мянган төгрөгийн 1 ажлыг гэрээг мэдээлээгүй байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Алтанбулаг сумын Засаг даргын эхний хагас жилийн санхүүгийн нэгтгэсэн тайланда завсрын аудит хийгдэгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн, сумын Засаг даргын 2022 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 05/152 дугаартай албан бичгээр хэрэгжилтийг ирүүлсэн байна.

Хүснэгт 10 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага					
Зөвлөмж	1	54,315.6	1	54,315.6	100
Нийт дүн	1	54,315.6	1	54,315.6	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Алтанбулаг сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланда дараагийн аудитаар анхаарал хандуулах асуудал байхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

5.1 Залруулсан алдаа

Аудитаар нийт 4,290,824.6 мянган төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад залруулав.

1. Байгалийн нөхөн сэргээлт барьцаа санд байршуулсан хүлээсэн үүргээ биелүүлэх баталгааны мөнгөн хөрөнгө 130.0 мянган төгрөгийг тайлант оны орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт. эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-д "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах" гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн "Иж бүрэн байх", "Үнэлгээ ба хуваарилалт" гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу залруулга хийгдсэн.

2. Нэгтгэсэн үр дүнгийн тайлан, тодруулга тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материалыг 5,000.0 мянган төгрөгөөр, үндсэн хөрөнгийг 7,193.6 мянган төгрөгөөр зөрүүтэй нэгтгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-д "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах" гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн "Иж бүрэн байх", "Үнэлгээ ба хуваарилалт" гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу залруулга хийгдсэн.

3. Нэгтгэсэн үр дүнгийн тайлан, тодруулга тайланд бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлсэн 4,156,758.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдлийг хасалгүй тайлагнасан, бараа материалыг 121,742.7 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар. энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-д "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах" гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн "Иж бүрэн байх", "Үнэлгээ ба хуваарилалт" гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу залруулга хийгдсэн.

Аудитаар нийт 174,231.7 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 174,231.7 мянган төгрөгийн 2 албан шаардлага өгсөн.

5.2 Албан шаардлага

Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө 112,5 хувиар давж биелсэн боловч 6 нэр төрлийн орлого 14,1-54,5 хувиар буюу 141,684.8 мянган төгрөгөөр тасарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1-д "Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бурдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ", 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн "нийцсэн бөгөөд зохистой байх" зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө" гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулгад 8 нэр төрлийн 32,546.9 мянган төгрөгийн татварын орлогыг татварын мэдээнээс зөрүүтэй тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бodoх бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "унэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бodoх бүртгэлийн стандарт, журам, заавар. энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бodoх бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-д "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах" гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн "Иж бүрэн байх", "Үнэлгээ ба хуваарилалт" гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө" гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
							Залруулсан		Залруулаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Засаг дарга	5	4,290,824.6			5	4,290,824.6	5	4,290,824.6		
ЗДТГ	4	32,199.1	1	7,049.1	3	25,150.0	4	32,199.1		
Дүн	9	4,323,023.7	1	7,049.1	8	4,315,974.6	9	4,323,023.7		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Хариуцлага тооцуулах албан шаардлага							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Албан тушаалтны тоо	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Засаг дарга	2	174,231.7			2	174,231.7				
ЗДТГ	3	770,309.7	1	180.0	1	180,805.7	1	589,324.0		
Дүн	5	944,541.4	1	180.0	3	355,037.4	1	589,324.0		

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
ОНХС	1	35,000.0							1	35,000.0
ХХС	1	171,809.8							1	171,809.8
ЭЭС	1	1,035.2							1	1,035.2
Дүн	3	207,844.9							3	207,844.9
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил										
Дүн										
Нийт дүн	3	207,844.9							3	207,844.9